

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 7181 дүгээрт бүртгэв.

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар А/14

Улаанбаатар
хот

“ТӨРИЙН АРХИВЫН БАРИМТАД НЭГДСЭН ТООЛЛОГО ЯВУУЛАХ ЖУРАМ”-ЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг, 17.1.7 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/204 дүгээр тушаалаар баталсан Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 6.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн архивын баримтад нэгдсэн тооллого явуулах журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төрийн архивын дарга, захирал, эрхлэгч нарт даалгасугай.

3.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Архивын ерөнхий газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/56 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.“Төрийн архивын баримтын нэгдсэн тооллого явуулах журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд хөдөлгөөн хийлгэхийг Захиргааны удирдлагын газар (Б.Баатарсүрэн)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, МЭРГЭЖИЛ,
АРГА ЗҮЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.ЦЭНДСҮРЭН

Энэ тушаалын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17430619245162>

ЗАВХАН АЙМГИЙН АСГАТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 39

Жавхлан

ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.10, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23, 8 дугаар зүйлийн 8.4, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас **ТОГТООХ нь:**

1.Сумын нийт нутаг дэвсгэрт оршин сууж байгаа айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллагууд, үйлдвэр үйлчилгээний газруудаас гарч байгаа ахуйн болон хуурай хог хаягдлын төлбөрийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж зориулалтын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга (Ц.Ганхуяг), татварын улсын байцаагч (М.Батсайхан) нарт даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Б.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.БАЯРЖАВХЛАН

*Асгат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 39 дүгээр
тогтоолын хавсралт*

	Үйл ажиллагааны чиглэл	Төлөх хугацаа	Төлбөрийн хэмжээ
А. Иргэн			
1	Нэг иргэн	сард	300
Б. Албан байгууллагууд			
2	Хүүхдийн цэцэрлэг	сард	5000
3	Ерөнхий боловсролын сургууль	сард	5000
4	Засаг даргын Тамгын газар	сард	5000
5	Соёлын төв	сард	5000
6	Эрүүл мэндийн төв	сард	5000
В. Аж ахуйн нэгжүүд			
1	Газар тариалангийн компани	сард	5000
2	Шатахуун түгээх станц	сард	4000
3	Банк санхүү	сард	4000
4	Шуудан холбоо	сард	2000
5	Цахилгаан түгээх холбоо	сард	2000
Г. Үйлчилгээний салбарууд			
1	Халуун усны газар	сард	2000
2	Зоогийн газар	сард	2000
3	Зочид буудал	сард	2000
4	Гутал засвар	сард	2000
5	Дугуй засвар	сард	2000
6	Машин угаалга, засвар	сард	2000
6	Мал нядалгааны цэг	Тухай бүр	10000
7	Баяр наадам, бусад арга хэмжээний үеэр үйлчилгээ явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд	Тухай бүр	10000
8	Уурын зуух	сард	10000

ДУНДГОВЬ АЙМГИЙН ГУРВАНСАЙХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 02

Суугаант

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийн 35.1.10, 35.1.14 дэх заалтууд, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсгийн 23.8.15 дахь заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь хэсгүүдийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчийн Хурлын ээлжит дөрөвдүгээр хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Сумын малын тоо толгойн албан татварын хэмжээг тэмээ-500 (Таван зуу)-н төгрөг, адуу-500 (Таван зуу)-н төгрөг, үхэр-500 (Таван зуу)-н төгрөг, хонь-300 (Гурван зуу)-н төгрөг, ямаа-400 (Дөрвөн зуу)-н төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

2.Энэхүү тогтоолыг Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөж, 2025 оны татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллахыг сумын Засаг дарга (Б. Энхтуяа), татварын байцаагч (Д.Загдсүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 44 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б. СОДНОМ

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 23

Улаанбаатар
хот

ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 45 дугаар зүйлийн 45.1, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.6, 41.7, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23, 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус нэгдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөх айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг нэгдүгээр, аж ахуйн нэгж, байгууллагаас үүссэн энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээний хураамжийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Д.Зоригт)-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Ө.Сумъяабаатар)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Төсөв, санхүү, эдийн засгийн хороо (Ю.Болормаа)-нд даалгасугай.

5. Тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 05/36 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

П.ӨЛЗИЙНАРАН

*Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт*

**АЙЛ ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНЭЭС ҮҮСЭХ ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

Д/д	Нэр төрөл	Нэг сард ногдох /төгрөгөөр/
1	Айл өрх	8,000 төгрөг

Тайлбар: Нэг өрхийн ам бүлийн тоог 2024 оны хүн амын тооллогын статистик үзүүлэлтийг үндэслэн дунджаар 4 хүнтэй байхаар тооцсон.

**Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 23 дугаар тогтоолын
хоёрдугаар хавсралт**

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллага бүр үйл ажиллагааны төрлөөс хамаарч сар бүр дор дурдсан хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлнө.

Хураамжийг дүүргийн Татварын хэлтсийн “Хог хаягдлын үйлчилгээний хураамж”-ийн дансанд төвлөрүүлнэ.

№	Төрөл	Хэлбэр	Үнэ тариф /тегрөг	Тайлбар
Худалдаа үйлчилгээ				
1	Худалдааны зах, төв	Хүнс, бараа, барилга, мод, авто	Рейсээр	
2	Их дэлгүүр	1000 м.кв дээш		
3	Хайпермаркет	1000 м.кв дээш		
4	Супермаркет	751-999 м.кв хүртэл		
5		500-750 м.кв хүртэл		
6	Минимаркет	251-499 м.кв хүртэл	250,000	
7		100-250 м.кв хүртэл	200,000	
8	Ая тухтай дэлгүүр	00 цаг хүртэл	200,000	
9		04 цаг хүртэл	250,000	
10	Хүнс, төрөлжсөн барааны дэлгүүр	41-100 м.кв хүртэл	100,000	
11		100 м.кв дээш	160,000	
12	Жимс, ногооны дэлгүүр	41 м.кв хүртэл	100,000	
13		41 м.кв дээш	160,000	
14	Ном, бэлэг дурсгал, гоо сайхан, барааны дэлгүүр	41 м.кв хүртэл	40,000	
15		41 м.кв-с дээш	80,000	
16	Барилгын материалын дэлгүүр			
17	Тавилга, гэр ахуйн барааны дэлгүүр	41 м.кв хүртэл	100,000	
18		41 м.кв дээш		
19	Компьютер, электрон барааны дэлгүүр	41 м.кв хүртэл	80,000	
20		41 - 100 м.кв хүртэл	120,000	
21	Автомашин	худалдаа	150,000	
22	Дахивар авах цэг		50,000	
23	Мухлаг		40,000	
24	Карго, онлайн захиалга		200,000	

Хоол үйлдвэрлэл үйлчилгээ				
1	Ресторан, лаунж, паб	Суудал тоо	8,000	
2	Караоке	Суудал тоо		
3	Баар /диско клуб, тайчих клуб/	Суудал тоо	10,000	
4	Баар /спорт/		160,000	
5	Кофе шоп		100,000	
6	Цайны газар	Суудал тоо	6,000	
7	Түргэн, хүргэлт, явуулын үйлчилгээтэй хоолны цэг	иргэн, аж ахуйн нэгж, байгууллага	80,000	
8	Сургуулийн цайны газар	1300 хүүхэд хүртэл	150,000	
9		1300 дээш хүүхэд	250,000	
10	Эвэнт танхимын үйлчилгээ		Рейсээр	
Ахуйн үйлчилгээ				
1	Үсчин		50,000	
2	Гоо сайхны салон	Гоо засал, хумс засал		
3	Бариа засал			
4	Үсчин гоо сайхны салон		80,000	
5	Хувцас, захиалга засвар		40,000	
6	Гутал засвар			
7	Ахуйн электрон, цахилгаан хэрэгслийн засвар			
8	Алт мөнгөний дархан, түлхүүр олшруулах цэг, цаг засварууд, үзмэрч, усны худаг		20,000	
9	Хими цэвэрлэгээ, угаалга		40,000	
10	Мод нүүрс худалдаалах цэг			
11	Канон, гэрэл зургийн үйлчилгээ			
12	Нотариат			
13	Нийтийн халуун ус			
14	Саун массаж		100,000	
15	Алжаал тайлах төв		160,000	
16	Ломбард	Энгийн	40,000	
17		Авто	60,000	
Зочлох үйлчилгээ				
1	Зочид, дэн буудал	Орны тоогоор	8,000	

Чийрэгжүүлэх, бялдаржуулах, тоглоомын үйлчилгээ				
1	Фитнес, спиннинг төв		60,000	
2	Усан бассейн			
3	Боулинг			
4	Аэробик, иог, спорт бүжгийн клуб			
5	Спорт заал			
6	Тоглоомын төв			
7	Биллиард, теннис	Ширээний тоо	15,000	
8	Цахим тоглоомын төв	Суудал тоо	3,000	
Авто үйлчилгээ				
1	Авто агрегат засвар		250,000	
2	Авто кузов засвар		300,000	
3	Дугуй засвар		60,000	
4	Автомашин угаалга	5 хүртэлх	100,000	
5		5-10 машин	150,000	
6		10-с дээш	200,000	
7	Авто сэлбэг, тос тосолгоо, будаг, аккумулятор, дугуй зэрэг ашиглалтын материалын дэлгүүр	35 м.кв хүртэл	50,000	
8		35-65 м.кв	100,000	
9		66 м.кв-с дээш	200,000	
10	Авто зогсоол	дулаан, ил	50,000	
11	Шатахуун түгээх станц		100,000	
Үйлдвэрлэл үйлчилгээ				
1	Үйлдвэрийн байгууллага	60 м.кв хүртэлх	100,000	
2		61-100 м.кв хүртэлх	180,000	
3		100 м.кв-с дээш	Рейсээр	
4	Бетон зуурмагийн үйлдвэр		100,000	Улирал
5	Хэвлэлийн үйлдвэр	60 м.кв хүртэлх	120,000	
6		61-100 м.кв хүртэлх	180,000	
7		100 м.кв-с дээш	Рейсээр	
8	Хүнсний үйлдвэр	60 м.кв хүртэлх	150,000	Жижиг цех
9		61-100 м.кв	250,000	
10		100 м.кв дээш	Рейсээр	
11	Агуулах			

Төрийн үйлчилгээний байгууллага			
1	Ерөнхий боловсролын сургууль	200,000	
2	Цэцэрлэг	100,000	
3	Их, дээд сургууль	Рейсээр	
4	Төрийн байгууллага	200,000	
5	Шуудан, харилцаа холбооны салбар	50,000	
Төрийн бус байгууллага			
1	Шашны байгууллага	Төв гандан	Рейсээр
2		Бусад	150,000
3	Радио телевизийн байгууллага	МҮОНРТ	Рейсээр
4		Бусад	150,000
5	Банк, банк бус санхүүгийн байгууллага	100,000	
Эм, эмнэлэгийн байгууллага			
1	Өрхийн эмнэлэг	50,000	
2	Улсын эмнэлэг	рейсээр	
3	Эмнэлэг /Амбулатор/	100,000	
4	Хэвтэн эмчлүүлэх эмнэлэг	20 хүртэлх ортой	200000
5		20-с дээш ортой	Рейсээр
6	Эм ханган нийлүүлэх төв	70,000	
7	Эмийн сан	40,000	
Бусад			
1	Оюутны дотуур байр	өрөө тоогоор	4,000
2	Нийтийн байр	өрөө тоогоор	8,000
3	Бүх төрлийн сургалтын төв		50,000
4	Оффис	0-100 м.кв хүртэл	50,000
5		101-200 м.кв хүртэл	100,000
6		200 м.кв дээш	150,000

Тайлбар: Ахуйн овор ихтэй хог хаягдал болон барилгын хог хаягдлын дуудлагын тээвэрлэлтийг дараах үнэлгээгээр тооцно.

1 рейсийн үнэлгээ 300,000 төгрөг

1 тн хог тээвэрлэх үнэлгээ 100,000 төгрөг

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 7185 дугаарт бүртгэв.

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 02 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 5/06

Баруун-Урт сум

МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДОХ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус тавдугаар Хурлаас **ТОГТООХ нь:**

1.Тус сумын малчин, мал бүхий иргэдийн өмчилж байгаа малын нэг толгойд ногдох албан татварын хэмжээг 2025 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал адуу - 0, үхэр - 0, ямаа - 0, хонь - 0, тэмээ - 0 төгрөг байхаар тус тус тогтоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Ж.Жавхаатөгс)-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг тооцож ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Багийн Иргэдийн Нийтийн хурал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн хороо (С.Адъяа)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн Ээлжит хорин гуравдугаар Хуралдааны 23/08 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Г.ИДЭРМӨНХ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 02 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 4/10

Пионер толгой

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалын 1, 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит 4 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт оршин сууж буй айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэр үйлчилгээний газруудаас гарч буй ахуйн болон хуурай хог хаягдлыг ачиж, тээвэрлэн зайлуулах, булшлах ажлын үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн батлагдсан үнэ, тарифын дагуу иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэр, үйлчилгээний газруудаас хураан барагдуулж орон нутгийн төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэх, зохих журмын дагуу зарцуулж хагас бүтэн жилээр биелэлт үр дүнг нь танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Мөнхдалай)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын бүрдүүлбэрийг хангаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (П.Тогтохжаргал)-д, Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ш.Нархүү) нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн 2021 оны 4 дүгээр хуралдааны 4/04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга (П.Тогтохжаргал)-д даалгасугай

ДАРГА

Б.БАЯНДАЛАЙ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2025 оны 02
дугаар сарын 24-ний өдрийн 4/10 дугаар тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН СУМЫН ХОГ
ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээний төрлүүд		Хэмжих нэгж	Хураамж мян./төг
1	Төрийн байгууллага	Энгийн хог хаягдал	Сар тутам (тн тутам)	15000
		Тусгай	Сар бүр	20000
2	Уурын зуухны хог хаягдал		Сар бүр	80000
3	Авто угаалга, дугуй засвар		Сар бүр	5000
4	Сумын төвд болон төв суурин газрын ойролцоо бүсэд байгаа мал бүхий өрхөөс		Сар бүр	10000
5	Худалдаа үйлчилгээний газар / дэлгүүр, гуанз, бар, рестран, хоолны үйлдэвэрлэлийн газар		Сар бүр	15000
6	Ил задгай талбайд худалдааны үйл ажиллагаа эрхлэгч дэлгүүр, баяр наадмын үеэр барьсан цайны газар, бусад цэгүүд		Тухай бүр	10000
7	Ноос, эсгийний үйлдвэр		Сар бүр	20000
8	Төв суурин газар нядалгаа хийсэн хуулийн этгээд	Иргэн	Тухай бүр (тн тутам)	15000
		Тухай бүр	20000	
9	Шатахуун түгээх станц		Сар бүр	10000
10	Барилгын хог хаягдал		Тухай бүр (тн тутам)	15000
11	Малчин өрх		Жилд	15000
12	Сумын төвийн өрх		Сар бүр	8000
13	Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй ААНБ	Ашиглалт	Ажиллах хугацааны сар тутам (тн тутам)	90000
			сул зогсолтын үеийн сар бүр (тн тутам)	15000
		Хайгуул	Ажиллах хугацааны сар бүр (тн тутам)	80000
		Бичил уурхай	Сар бүр	50000

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 7187 дугаарт бүртгэв.

ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 02

Хөдрөг

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Малын тоо толгойн албан татварыг малын төрөл тус бүрээр дараах байдлаар тогтоож баталсугай.

д/д	Малын тоо толгойн төрөл	Ногдуулах татвар
1	Адуу	600
2	Үхэр	400
3	Хонь	400
4	Ямаа	600

2.Татварыг хуулийн хугацаанд орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг татварын байцаагч /Д.Балжинням/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /П.Бадамханд/-д даалгасугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2021 оны 01 сарын 13 өдрийн 02 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

З.БАЯРМАГНАЙ

БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 02 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар А/55

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Дээд боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэхүү журмыг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэхийг өмчийн хэлбэр үл харгалзан дээд боловсролын сургалтын байгууллага болон эрдэм шинжилгээний байгууллагын ректор, захирал нарт үүрэг болгосугай.

3.Журмын хэрэгжилтийг хангах чиглэлээр Үндэсний шинжлэх ухаан, технологийн сантай хамтран ажилла хыг Дээд боловсролын бодлогын газар (Ж.Ариунболд), Цахим боловсролын газар (Т.Бат-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

4.Тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны “Журам батлах тухай” А/332 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД

П.НАРАНБАЯР

*Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн
А/55 дугаар тушаалын хавсралт*

СУДАЛГААНЫ АЖЛЫН ХУУЛБАРЛАЛТЫГ ШАЛГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журам (цаашид “журам” гэх)-ын зорилго нь дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач, суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн хуулбарлалтын хувь хэмжээг тогтоох, нэгдсэн мэдээллийн санг бий болгох, хадгалах, хамгаалах, баяжуулах, түүнийг ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журмыг дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач, суралцагч, Дээд боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан байгууллага (цаашид “Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан” гэх) болон цахим дэд бүтэц хариуцагч дагаж мөрдөнө.

1.3.Журмын хүрээнд бакалаврын дипломын ажил, магистрын төгсөлтийн ажил, докторын диссертац, эрдэм шинжилгээний өгүүлэл, төслийн тайлан, сурах бичиг, гарын авлага болон нэг сэдэвт бүтээл (цаашид “судалгааны ажил” гэх)-ийн хуулбарлалтыг шалгана.

1.4.Багш, судлаач, суралцагч нь бусдын оюуны бүтээл, судалгааны ажлыг ашиглахдаа шударга, ёс зүйтэй байх зарчмыг баримтална.

1.5.Зохиогчийн эрхийн тухай хуульд заасан зөрчлийг энэхүү журмаар зохицуулахгүй.

Хоёр.Хуулбарлалтыг шалгах үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1.Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгахдаа дараах байдлаар зохион байгуулна.

2.1.1.Энэхүү журмын 1.3-т заасан судалгааны ажилд эх сурвалжийг дурдалгүй, эшлэл, зүүлт хийхгүйгээр хуулбарлах, өөрийн судалгааны ажлыг дахин ашиглахыг хуулбарлалт гэж үзнэ.

2.1.2.Өгөгдлийн нэгдсэн сан (цаашид “нэгдсэн сан” гэх)-д Үндэсний шинжлэх ухаан технологийн сан, дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, цахим дэд бүтэц хариуцагчийн сан дахь энэхүү журмын 1.3-т заасан бүтээл болон цахим орчин дахь бусад нээлттэй эх сурвалж хамаарна.

2.1.3.Хуулбарлалтыг шалгахдаа нэгдсэн санд судалгааны ажлыг шалгаж хуулбарлалтын хувийг тогтооно.

2.1.4.Нэгдсэн санд хадгалагдаж байгаа өгөгдөлтэй судалгааны ажлыг харьцуулахад илэрч буй давхцал болон төсөөтэй байдлын нэгдсэн дүнг илэрхийлсэн хувиар хуулбарлалтын хувийг тодорхойлох бөгөөд дараах байдлаар тогтооно:

2.1.4.1.Судалгааны ажлыг нэгдсэн санд хадгалагдаж байгаа өгөгдөлтэй харьцуулан ижил төстэй, давхцаж байгаа хэсгүүдийг илрүүлсэн дүнгээр давхцалыг,

2.1.4.2.Судалгааны ажлыг нэгдсэн санд хадгалагдаж байгаа өгөгдөлтэй харьцуулахад үгийн байрлалыг сольсон, ижил болон ойролцоо утга, агуулгатай үгээр орлуулан найруулсан өгүүлбэр, хэсгийн дүнгээр төсөөтэй байдлыг.

2.1.5.Судалгааны ажлын хуулбарлалтын хувийг тогтоох программ хангамжийг нийлүүлэх, аюулгүй байдлыг хангах хуулийн этгээд (цаашид “цахим дэд бүтэц хариуцагч” гэх)-ийг сонгон шалгаруулж, хамтран ажиллана.

2.2.Дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага нь судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах үйл ажиллагааг цахим дэд бүтэц ашиглах гэрээний дагуу Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан болон цахим дэд бүтэц хариуцагчтай хамтран хэрэгжүүлнэ.

2.3.Энэхүү журмын 2.2-т заасан гэрээнд судалгааны ажил бичиж, туурвин хуулбарлалтын хувийг тогтоолгохоор хүсэлт гаргасан байгууллага, багш, судлаач, суралцагч (цаашид “шалгуулагч” гэх) болон дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, цахим дэд бүтэц хариуцагчийн эрх, үүрэг, хариуцлага, хяналт, төлбөр, системийн хэвийн үйл ажиллагаа, хөгжүүлэлт, аюулгүй байдал, нууцлал, давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг тодорхой тусгана.

2.4.Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгуулах зардлыг шалгуулагч өөрийн зардлаар, цахим дэд бүтцийн ажиллагаатай холбоотой гарах зардлыг дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага хариуцна.

2.5.Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжсэн судалгааны ажлын хуулбарлалтыг шалгахтай холбоотой гарах зардлыг тухайн төслийн гүйцэтгэгч хариуцна.

2.6.Шалгуулагч энэхүү журмын 1.3-т заасан судалгааны ажлын хуулбарлалтыг өөрийн зардлаар урьдчилан шалгуулж болно.

2.7.Нэгдсэн санд оруулах судалгааны ажил нь хайлт хийх боломжтой PDF форматтай, 36 мегабайтаас ихгүй файл байх бөгөөд судалгааны ажлын нэр, товч тайлбар, судлаачийн нэр, судалгааны

ажлын төрөл, зориулалт, туурвисан огноо зэрэг бүрдэлтэй байна.

Гурав.Хуулбарлалтыг шалгах үйл ажиллагаанд оролцогч талын чиг үүрэг

3.1.Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1.цахим архивд нэгдсэн санг үүсгэх, баяжуулах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.1.2.цахим дэд бүтэц хариуцагчийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хамтран ажиллах;

3.1.3.дээд боловсролын сургалтын байгууллагаас докторын диссертац, эрдэм шинжилгээний байгууллагаас гүйцэтгэсэн судалгааны ажлын тайланг цахим болон хэвлэмэл хувийг хүлээн авах, хадгалах;

3.1.4.нэгдсэн сангийн цахим архивд энэхүү журмын 3.1.3-д заасан шинээр нэмэгдсэн диссертац, судалгааны ажлын тайланг жил бүрийн хоёрдугаар сарын 10-ны өдрийг хүртэл баяжилт хийх;

3.1.5.Үндэсний шинжлэх ухаан, технологийн санд өөрийн судалгааны ажлын цахим санг үүсгэх хүсэлт гаргасан дээд боловсролын сургалтын байгууллага,

эрдэм шинжилгээний байгууллагын сангийн хадгалалт, системийн аюулгүй байдлыг хариуцах;

3.1.6.хуулбарлалтыг шалгах үйл ажиллагааны тайланг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хагас жил тутам хүргүүлэх.

3.2.Цахим дэд бүтэц хариуцагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1.нэгдсэн сан үүсгэх программ хангамжийг нийлүүлэх, суурилуулах;

3.2.2.судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах нэвтрэх эрхийг үүсгэх;

3.2.3.программ хангамжийг ашиглах, хуулбарлалтыг шалгахтай холбоотой заавар, зөвлөгөө өгөх, сургалт мэдээллээр хангах, тусламж үйлчилгээг үзүүлэх;

3.2.4.цахим дэд бүтцийн нууцлал, аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагааг хангах.

3.3.Дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1.өөрийн байгууллагын судалгааны ажлын санг үүсгэх, нэгдсэн санд байршуулах;

3.3.2.Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан, цахим дэд бүтэц хариуцагчтай мэдээлэл солилцох;

3.3.3.багш, суралцагч, судлаачдад судалгааны ажлын

хуулбарлалт, түүнээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө, мэдээллийг тогтмол өгөх;

3.3.4.нэгдсэн сангийн цахим дэд бүтцийг ашиглан шалгуулагчийн судалгааны ажлын хуулбарлалтын лавлагаа гаргах, холбогдох хууль, тогтоомжийн дагуу архивд хадгалах;

3.3.5.нэгдсэн сангийн цахим дэд бүтэц ашигласан төлбөрийг гэрээний дагуу төлөх;

3.3.6.шалгуулагчийн эрх, ашгийг хамгаалах.

Дөрөв.Судалгааны ажлын хуулбарлалтын хувь

4.1.Дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага шалгуулагчийн судалгааны ажлыг цахимаар хүлээн авч, хуулбарлалтыг шалгаж лавлагааг шалгуулагчид цахим болон хэвлэмэл байдлаар хүргүүлнэ.

4.2.Судалгааны бүтээлүүдийн хуулбарлалтын хувь дор дурдсанаас хэтрэхгүй байна.

4.2.1.төслийн тайлан, нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний өгүүлэл 20 хувь;

4.2.2.докторын диссертац 20 хувь;

4.2.3.магистрын төгсөлтийн ажил 25 хувь;

4.2.4.бакалаврын дипломын ажил 30 хувь;

4.3.Судалгааны ажлын хуулбарлалтын хувь энэ журмын 4.2-т заасан хувиас хэтэрсэн тохиолдолд тухайн судалгааны ажлын хуулбарлалтын дүнг шалгуулагчид мэдэгдэж, эцсийн хамгаалалтад оруулахгүй, хүлээн авахгүй.

Тав.Бусад

5.1.Нэгдсэн санд ороогүй судалгааны ажлаас хуулбарласан байх нь энэ журмын зохицуулалтад хамаарахгүй бөгөөд маргаан гарсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

5.2.Нэгдсэн санд байршуулсан судалгааны ажлыг зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй бөгөөд хуулбарлалтын хувь хэмжээг шалгуулагч, шийдвэр гаргах эрх бүхий нэгжээс бусад этгээдэд мэдээлэхгүй.

5.3.Төрийн болон албаны нууцад хамаарах дүгнэлттэй судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагын чиг үүргийн хүрээнд зохицуулна.

5.4.Дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага судалгааны ажлын хуулбарлалттай холбоотой гомдол, маргааныг хүлээн авч, шийдвэрлэнэ. Шаардлагатай бол дэд бүтэц хариуцагч, Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангаас холбогдох лавлагааг авч болно.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 7189 дүгээрт бүртгэв.

СҮХБААТАР АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар 4/33

Ширээт

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1,48.2, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг Сумын ИТХ-ын төлөөлөгчдийн тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн сумын ИТХ-ын төлөөлөгчдийн ээлжит 4 дүгээр хуралдаанаар хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

1. 2023,2024 онд байгаль цаг агаарын хүндрэлтэй байсаны улмаас мал сүрэг олноор хорогдож, амжиргаа ихээр буурсан тул амьжиргааг дэмжих зорилгоор малын тоо толгойг төрөл бүрээр /тэмээ, адуу, үхэр, хонь, ямаа/ албан татварын хувь хэмжээг 2025 онд /0/ тэг төгрөг байхаар тогтоосугай.

2.Татвартай холбоотой ажлыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг сумын засаг дарга /Д.Аваажигмэд/, татварын байцаагч /Б.Батгэрэл/ нарт даалгасугай.

3.Энэхүү тогтоол хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 9/70 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын санхүү эдийн засгийн хяналтын хороонд даалгасугай.

ДАРГА

Я.ЭРДЭНЭБАТ

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНХУТАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН 03 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 03 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 06

Баянхутаг сум

МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДОХ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн” 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, 20.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалт, “Малын тоо толгойн албан татварын тухай “хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит 3-р хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөх малын тоо толгойд ногдох албан татварын хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Малын тоо толгойн албан татварыг хуульд заасан хугацаанд орон нутгийн төсөвт төвлөрүүлж, Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заагдсан үйл ажиллагаанд зарцуулан ажиллахыг сумын Засаг дарга /Д.Байгалмаа/-д, татварын орлого төвлөрүүлэлтэнд хяналт тавин ажиллаж, тайланг хагас бүтэн жилээр иргэдийн Төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг татвар хураагч /С.Алимаа/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороо /Б.Алтангэрэл/-д үүрэг болгосугай.

4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Д.ЦОЛМОН

*Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2025 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн
06 дугаар тогтоолын 01 дугаар хавсралт*

МАЛЫН ТОО ТОЛГОЙД НОГДОХ АЛБАН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ

№	Малын тоо толгойн албан татвар /тоо толгойд ногдоно/		0 төгрөг ногдох албан татвар /малчны өмчилж байгаа малын тоо толгойноос чөлөөлөгдөх нь/	
	Төрөл	Татвар	Төрөл	Тоо толгой
1	Тэмээ	0 төгрөг	Тэмээ	0
2	Адуу	800 төгрөг	Адуу	15
3	Үхэр	500 төгрөг	Үхэр	15
4	Хонь	300 төгрөг	Хонь	100
5	Ямаа	300 төгрөг	Ямаа	50

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 02

Эрдэнэбулган сум

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дах хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс БАТЛАХ нь:

1.“Долоон бар” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Хашаат сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, «Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл»-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн тус тус мөрдөж ажиллахыг Архангай аймгийн Хашаат сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /А.Алтанчимэг/-д даалгасугай.

ДАРГА

А.АЛТАНЧИМЭГ

ГИШҮҮН
ГИШҮҮН

С.БАТСҮХ
А.БАТБОЛД

*Архангай аймгийн Зохицуулах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын
24-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралт*

**“ДОЛООН БАР” ХХК-НЫ ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД
ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Архангай аймгийн “Долоон бар” ХХК-ны дулаан түгээх сүлжээнд холбогдсон Хашаат сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт	Төг/м ³	1,733
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	9,821
	Тогтмол	Төг/м ³	261
6	Орон сууцны халаалт (хүн амьдарч буй талбай хамаарна)	Төг/м ²	1,100

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 03

Эрдэнэбулган сум

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дах хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс БАТЛАХ нь:

1.“Эсгэл” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Эрдэнэбулган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралт ёсоор баталсугай.

2.Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, ахуйн хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн тус тус мөрдөж ажиллахыг Архангай аймгийн Эрдэнэбулган сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эсгэл” ХХК /Н.Чулуунбат/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /А.Алтанчимэг/-д даалгасугай.

ДАРГА

А.АЛТАНЧИМЭГ

ГИШҮҮН
ГИШҮҮН

С.БАТСҮХ
А.БАТБОЛД

*Архангай аймгийн Зохицуулах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын
24-ний өдрийн 03 дугаар тогтоолын хавсралт*

**“ЭСГЭЛ” ХХК-НЫ ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДСОН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Архангай аймгийн “Эсгэл” ХХК-ны дулаан түгээх сүлжээнд холбогдсон Эрдэнэбулган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно.

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт		Төг/м ³	2,359
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	1,905
		Тогтмол	Төг/м ³	61
3	Орон сууцны халаалт (хүн амьдарч буй талбай хамаарна)		Төг/м ²	810

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 02 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ын 2.1, 2.2, 2.3 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 115 дугаар тогтоол, Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 115 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай” 749 дүгээр тогтоолын 2 дахь заалтын “Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын цагийн ялгаварт тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт 100 хувийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын хэрэглээний дээд хязгаарыг 220 В-ын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 700 кВт.цаг, 380 В-ын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 1500 кВт.цаг байхаар тус тус тогтоосугай” гэж заасныг “Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын цагийн ялгаварт тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт 100 хувийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын хэрэглээний дээд хязгаарыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 220 В-ын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 1500 кВт.цаг, 380 В-ын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 3000 кВт.цаг байхаар тогтоосугай” гэж өөрчилсүгэй.

2. Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Тарифт хөнгөлөлт үзүүлэх тухай” 749 дүгээр тогтоолын 4 дэх заалтад “Цахилгаан шугам, сүлжээний тоног төхөөрөмжийн найдвартай, аюулгүй ажиллагааг хангах, гэр хорооллын өрхөд цахилгааны ашиглалтын аюулгүй байдалтай холбоотой сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг цахилгаан

түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай” гэж заасныг “Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын цагийн ялгаварт тарифт тоолууртай өрхийн өглөөний 06.00 цагаас 09.00 цагийн хооронд хэрэглэсэн цахилгааны тарифт 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 100 хувиар хөнгөлөлт үзүүлэхийг цахилгаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.” гэж өөрчилсүгэй.

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ

П.ТОВУУДОРЖ
Л.ДАШМЯГМАРЖАВ
Ц.НОРОВЖАМЦ
Д.ЦОГОО

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар 759

Улаанбаатар
хот

ТОГТООЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.Цахилгаан тэжээлт автомашин цэнэглэгч станцууд нь бусад үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын ангилалд хамаарах болсонтой холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Тариф батлах тухай” 404, 405, 406 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулга)-т даалгасугай.

ДАРГА

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ
ЗОХИЦУУЛАГЧ

П.ТОВУУДОРЖ
Л.ДАШМЯГМАРЖАВ
Ц.НОРОВЖАМЦ
Д.ЦОГОО

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд
2025 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр хүлээн авсан*

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2025 оны 04 дүгээр
сарын 01-ний өдөр

Дугаар А/96,А/63

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэг, Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Журам батлах тухай” (Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл импортлох, худалдах болон спорт-сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээд галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх журам) Хууль зүйн сайд, Сангийн сайдын 2015 оны А/251, 304 дүгээр хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Хүчингүй болсон тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасуулах арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Н.Мягмар/-д даалгасугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

О.АЛТАНГЭРЭЛ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар А/100

Улаанбаатар
хот

ТУШААЛ, ЖУРАМ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хууль, “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын хуралдааны 2024 оны №39 тэмдэглэл, “Аргачлал батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны №84 тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай” Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны №1/2516 албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тушаал батлахад үндэслэл болгосон “Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах ажлыг зохицуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоол нь “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 195 дугаар тогтоол (Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам)-оор хүчингүй болсон тул Гаалийн ерөнхий газрын даргын “Журам батлах тухай” 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн №660 тушаал/ Хураагдсан бараа, тээврийн хэрэгслийг борлуулах журам/-ыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Д.Долгорсүрэн), Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлд хөдөлгөөн хийлгэх арга хэмжээ авч ажиллахыг Хуулийн хэлтэс (Ч.Тамираа)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар А/101

Улаанбаатар
хот

ТУШААЛ, ЖУРАМ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хууль, “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын хуралдааны 2024 оны №39 тэмдэглэл, “Аргачлал батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны №84 тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай” Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны №1/2516 албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар зөвлөгөө өгөх дотоод үндсэн чиг үүрэгт заасан үйл ажиллагааг нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээ болгож тогтоон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлд бүртгүүлсэн Гаалийн ерөнхий газрын даргын “Журам батлах тухай” 2008 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн №735 тушаал (Гаалийн хууль тогтоомжтой холбогдсон асуудлаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх журам)-ыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан байгууллагын дотоодод дагаж мөрдөх, Гаалийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан зөвлөгөө өгөх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулж ажиллахыг Хуулийн хэлтэс (Ч.Тамираа)-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлд хөдөлгөөн хийлгэх арга хэмжээ авч ажиллахыг Хуулийн хэлтэс (Ч.Тамираа)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газар (Б.Хосбаяр)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 дугаар
сарын 19-ний өдөр

Дугаар А/102

Улаанбаатар
хот

ТУШААЛ, ЖУРАМ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6 дахь заалт, “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын хуралдааны 2024 оны №39 тэмдэглэл, “Аргачлал батлах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны №84 тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”, “Хяналт-шинжилгээ, үнэлгээний тухай” Хууль зүй, дотоод хэргийн яамны 2024 оны №1/2516 албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Гаалийн тухай хуулиар гаалийн удирдах төв байгууллагын дарга батлах тусгайлсан эрх олгоогүй байхад баталж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоон эрх зүйн зөрчил үүсгэсэн “Заавар батлах тухай” 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн №А/62 тушаал(Бүрэн буюу бүрэн бус суудлын автомашин, суудлын автомашины кузовыг тодорхойлон ангилах заавар)-ыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан шаардлагатай бол байгууллагын дотоодод дагаж мөрдөх, бүрэн буюу бүрэн бус суудлын автомашин, суудлын автомашины кузов тодорхойлон ангилах үйл ажиллагааны заавар боловсруулж, батлуулж ажиллахыг Барааны ангилал, үнэлгээний хэлтэс (Ч.Чимгэрэл), Бүрдүүлэлтийн цахим төв(Э.Лхагвасүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн бүртгэлд хөдөлгөөн хийлгэх арга хэмжээ авч ажиллахыг Хуулийн хэлтэс(Ч.Тамираа)-т тус тус даалгасугай.

ДАРГА

Р.ОТГОНЖАРГАЛ

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙДЫН ТУШААЛ

2025 оны 01 дүгээр
сарын 27-ны өдөр

Дугаар А/19

Улаанбаатар
хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.3, 35.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг 1 дүгээр, Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авахад шаардлагатай бичиг баримтын бүрдлийг 2 дугаар, Баяжуулах үйлдвэрийг хүлээн авахад шаардлагатай бичиг баримтын бүрдлийг 3 дугаар, Улсын комиссын актын загварыг 4 дүгээр, Улсын комиссын хурлын тэмдэглэлийн загварыг 5 дугаар, Улсын комиссын албан даалгаврын загварыг 6 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үйл ажиллагаагаа эхлүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж, хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгжийн уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах талаар шийдвэр гаргах үүрэг бүхий Улсын комиссыг тухай бүр томилон ажиллуулахыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Жавхланбаатар/-д даалгасугай.

3.Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журмыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Геологи уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /Д.Сагараадорж/-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/303 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Ц.ТУВААН

